



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 4 сарын 1 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо  
байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс зүйн дэд хорооны дарга:

Н.Ганболд

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Дэлгэрмаа

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

В.Дарханбаатар

Төрийн өмчийн удирдлага,  
зохицуулалтын хэлтсийн Удирдлага,  
төлөөллийн албаны дарга

Д.Отгонтуяа

Ерөнхий нягтлан бодогч

Г.Туул

Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах  
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга

Н.Дагиймаа


Хүний нөөцийн мэргэжилтэн

2.Байгууллагын ажиллагсдыг ёс зүйн зөрчил гаргуулахгүй байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан шалгаж дүгнэлт гаргах, холбогдох тайлан мэдээг Ёс зүйн хороонд хүргүүлж ажиллахыг Ёс зүйн дэд хороо /Н.Ганболд/-д даалгасугай.

3. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг сар бүрийн албан тушаалын үндсэн цалингаас 20 хувиар тооцон олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Отгонтуяа/-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн А/24 дүгээр тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ 132013913